

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024-01-10

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Эрүүл мэндийн газрын жилийн турш хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд жилийн эцсийн байдлаар хяналт үнэлгээ хийж, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, удирдлагыг бодит мэдээлэл, санал зөвлөмжөөр хангахад оршино.

Ерөнхий мэдээлэл

Эрүүл мэндийн газар нь 2014 оноос эхлэн бүтэц орон тоонд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэстэй болж, улмаар эрүүл мэндийн байгууллагад хяналт-шинжилгээ, үнэлгээний хийх нийтлэг журамтай ажиллаж байна. Тус хэлтсийн бүрэлдэхүүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан 1, дотоод аудитын 1 мэргэжилтэн ажиллаж, хяналт үнэлгээ, дотоод аудитыг зохион байгуулж, бүх мэргэжилтнийг оролцуулдаг. Хийгдсэн хяналт үнэлгээний дагуу ажлын хэсэг зөвлөмж хүргүүлж, биелэлтийг дараагийн хяналт үнэлгээгээр хянаж ажиллаж байна.

Тайлант онд “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам” батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж, “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх нийтлэг аргачлал”-ын хавсралт болох ЭМЯ болон аймгийн ЗДТГ-т хүргүүлэх тайлангуудын хуваарийн дагуу хагас, бүтэн жилээр зохих журмын дагуу хугацаандаа хүргүүлсэн.

Эрүүл мэндийн газраас зохион байгуулагдсан хяналт үнэлгээ, дотоод аудит

Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх нийтлэг аргачлал” дагуу тус оны эхний хагас жилийн байдлаар Эрүүл мэндийн газраас харьяа эрүүл мэндийн байгууллагуудад нийт 40 удаагийн хяналт үнэлгээ зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 75 байгууллагыг хамруулсан байна. Үүнд:Эх, хүүхдийн идэвхтэй хяналт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, магадлан итгэмжлэлд орох харьяа байгууллагуудад явцын үнэлгээ, эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийн явц, статистик мэдээлэл, шинээр тусгай зөвшөөрөл хүсэгч байгууллагуудын орон байрыг үнэлэх, өргөдлийн мөрөөр болон хаваржилт хүндэрсэн сумдад хяналт үнэлгээ, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг гурвалсан гэрээний дагуу хагас, бүтэн жилээр дүгнэх хяналт үнэлгээнүүд хийгдэж, мэргэжил арга зүйгээр хангаж, зөвлөмжүүд хүргүүлж ажиллалаа.

Үүнээс гадна Эрүүл мэндийн даргын баталсан удирдамжаар АНЭ-д 2 удаа, 12 сумуудад нэг удаа, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нэг удаа тус тус очиж санхүүгийн бэрхшээлд орох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор харьяа эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйгээр хангах, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, санхүүгийн үйл ажиллагаанд нь мөрдөн ажиллах шинэчлэгдсэн эрх зүйн актуудыг танилцуулан, мэргэжил арга зүйгээр хангаж, зөвлөмж хүргүүлэн ажилласан.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 05 тоот тогтоолын 3 дугаар зүйлийн 3.12 дахь заалтын дагуу баталсан “Сум, тосгоны эрүүл мэндийн төв”-д ажиллах хүний нөөцийн доод хязгаарыг батлах тухай”

аймгийн Эрүүл мэндийн газрын даргын А/51 дүгээр тушаалын биелэлтэд тогтмол хяналт тавьж, Хөдөлмөрийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2018 оны 382, 2019 оны 05, 33, 2023 оны 240, 241 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/548 тоот тушаал, 2019 оны А/611 тоот тушаал, стандарт зэрэг холбогдох эрх зүйн актуудыг мөрдөн ажиллаж, төсвийн сахилга батыг чанд сахиж, батлагдсан орон тооны дэд хязгаарт багтаан, тэтгэвэрт гарсан хүний оронд шинээр хүн нэмж авахгүй байж, тэвчиж болох зардлуудаа хэмнэн төлөвлөгөө боловсруулан ажиллахыг зөвлөн ажиллалаа.

ТАЙЛАН ТУС БҮРИЙН ҮНЭЛГЭЭ

1. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ 98%
2. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА БАЙГУУЛЛАГЫН ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ 96,7%
3. БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 96.7%
4. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ 90.6%
5. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙЛДЛЫН ТАЙЛАН 94.1%
6. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ 86.1%
7. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ 80%
8. МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО АЛСЫН ХАРАА-2050 БАРИМТ БИЧГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТ 70%
9. МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 77%
10. АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 77%
11. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 85.1%
12. ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ 100%
13. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛААР БАТЛАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН 93.6%
14. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ТАЙЛАН 90%

ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН
(2023 он)

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	90	0.6	
	2.Зорилтот хөтөлбөр болон Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	93.6		
	3. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	85.1		
	4. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт	77		
	5. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	-		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Аймгийн Засаг даргын байгууллагын даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	96.7	0.2	0.89
	2. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	96.7		
	3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	90.6		
	4. Иргэдээс ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлт	95		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	94.1	0.2	
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	100		
Ерөнхий үнэлгээ:			1.0	

Аймгийн Засаг даргын 2021 оны А/751, 2022 оны А/1012 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 9.3-т заагдсан дараах тайланг хавсаргав.

Тайлан бичсэн:

ЭМГ-ын

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга

Ш.Иманхан